

2025 оны 10 дугаар сарын ...-ний өдөр

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, МОНГОЛ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, мөн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж заасан.

Улсын Их Хурлын үйл ажиллагааг зохицуулах дэгийн хуулийг боловсронгуй болгох шаардлага тулгардаг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ ард иргэдийн хүсэл зориг, эрх ашигт тулгуурлан шийдвэр гаргах нь парламентын үйл ажиллагааны гол зарчим мөн.

Ардчилсан нийгэмд парламентын хэлэлцүүлгийн санал хураалтын ил тод, бодитой, үр нөлөөтэй, агуулгын хувьд тодорхой байдал нь төрийн бодлого иргэдэд хүрэх болон итгэл хүлээх чухал нөхцөл болдог.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль нь хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулах үндсэн зохицуулалт бөгөөд энэ хуулиар хуралдаан, хэлэлцүүлэг, санал хураалтын дэгийг тодорхойлдог.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд “Санал хураалт явуулах ерөнхий журам”-ыг хуульчилсан бөгөөд 10.8 дах хэсэгт “Гишүүн санал хураалтад оролцохдоо “зөвшөөрсөн”, эсхүл “татгалзсан” саналын аль нэгийг өгнө.” гэж заасан байдаг.

Энэ заалт нь нэг талаас парламентын гишүүд ард түмний төлөөлөл гэсэн байр сууринаас өөрийн үзэл бодлоо илэрхийлж, санал хураалтаараа ардчиллын ил тод байдлыг баталгаажуулдаг бол нөгөө талаасаа гишүүдийн үйл ажиллагаанд олон нийт хяналт тавих чухал хэрэгсэл болж өгдөг.

Дээрх зохицуулалтын дагуу чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж буй асуудлыг шийдвэрлэхдээ Байнгын хороо, хянан шалгах түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн шийдвэрийг үндэслэн, тухайн асуудлыг дэмжих эсэх талаарх санал хураалтыг явуулдаг ба асуудлыг хэлэлцэхдээ Байнгын хороо, түр хороонд анх оруулсан саналыг бус, хэлэлцэж гаргасан санал, дүгнэлт, байр суурьд тулгуурлан шийдвэрлэх хэлбэр рүү хэлбийх хандлагатай байна.

Үүний улмаас зарим тохиолдолд хэлэлцэж буй асуудлын бодит агуулга, зорилгын хувьд ойлголтын зөрүү үүсэж, шийдвэр гаргахад оролцоогүй гишүүдийн ирц саналын үр дүнд автоматаар нөлөөлж, ард иргэдийн зүгээс мөн хуралдааны үйл явц, үр дүн, агуулгатай холбоотой ойлгомжгүй байдал үүсэж байна.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан Байнгын хорооны хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах дэгд тодорхой өөрчлөлт оруулах, Байнгын хорооны хуралдаан дээр гарч байгаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бүгдийг нь нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, санал хураалгах бус тодорхой саналуудыг дэмжээгүй бол тухайн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхэд яригдсан байдал, санал гаргасан гишүүн, нам, эвслийн бүлэг, ажлын хэсгийн саналыг харгалзан чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлдэг байх шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуульд Ерөнхий сайд өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсаны дараа Засгийн газрын гишүүнийг томилж, чөлөөлж, огцруулахаар заасан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Улсын Их Хуралд танилцуулах хугацааг нарийвчлан зааж өгөх нь зүйтэй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл, хэсэгт заасан хугацааг Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх шаардлагатай байна.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага

Гишүүдийн санал нь хэлэлцэн шийдвэрлэхээр зорьж буй асуудлын гол утга агуулга, үр дүнд бүрэн тусахгүй, харин процедурын шинжтэй хэлбэрт хязгаарлагдсанаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн асуудлын агуулга, зорилго, үндэслэлийг бүрэн дүгнэх, үндсэн агуулга болон үр дүнтэй шийдвэр гаргах нөхцөлийг хангахгүй бөгөөд Улсын Их Хурлын шийдвэр гаргах чанарыг бууруулах, асуудлын бодит байдал, гарах үр дүнг өөрчлөх эрсдэлтэй.

Тиймээс дээрх ойлголтын зөрүүг арилгах, хэлэлцэж буй асуудлыг өнгөц санал хураалтаар шийдвэрлэх бус Улсын Их Хурал нь ард түмний төлөөлөл гэх утгаараа тухайн асуудалд агуулгын хувьд өөрийн үзэл бодлоо үр дүнд нөлөөлөхүйц, ил тод байдлаар илэрхийлэн саналаа өгдөг байх хэрэгтэй.

Үүний тулд хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр “Чуулганы нэгдсэн хуралдаанаар асуудлыг шийдвэрлэхдээ Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонх дэмжсэн, дэмжээгүйгээс үл хамаарч эрх бүхий этгээдийн анх оруулсан саналыг нь “дэмжих эсэх”-ээр санал хураана” гэх агуулгыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэгт нэмж зохицуулах шаардлагатай байна.

Ингэснээр санал хураалтын үр дүн нь тухайн асуудлын бодит агуулга, зорилго, эрх зүйн зорилтот хүрээнд төвлөрч, шийдвэр гаргах үйл явцад оролцсон гишүүдийн байр суурь шууд тусгагдах юм.

Мөн энэхүү зохицуулалт нь ирцийн нөлөө болон олон нийтийн ойлголтын зөрүүтэй байдлыг бууруулж, чуулганы шийдвэр гаргах үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдал болон шийдвэр гаргах үйл явцыг процедурын бус, бодлогын

агуулгад суурилсан, илүү үр нөлөөтэй, ил тод болгож, парламентын үйл ажиллагаанд иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх чухал алхам болохоос гадна парламентыг төлөөллийн ардчиллын зарчимд нийцүүлэх гэх талаараа өргөн хүрээний чухал ойлголт болж байгаа юм.

Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Засгийн газрын гишүүнийг томилж, чөлөөлж, огцруулахаар хуульчилсан бөгөөд Улсын Их Хуралд танилцуулах тухайгаа Улсын Их Хурлын даргад мэдэгдэж, товыг тогтоолгохоор заасан ч зарим үед Улсын Их Хуралд танилцуулах хугацааг товлохгүй байх тохиолдол гарч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой хугацаа заасан зохицуулалтаас өөрөөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг баталсан байгааг Үндсэн хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 6 зүйлтэй байхаар боловсруулна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

- Засгийн газрын гишүүнээр томилох тухай асуудал болон Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, огцруулах, түүнтэй холбогдуулан шинээр томилох асуудлын талаарх Ерөнхий сайдын танилцуулгыг хүлээн авснаас хойш уг асуудлыг ажлын 5 хоногийн дотор чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан байхаар товыг тогтоох, мөн хуулийн холбогдох зохицуулалт болох 26.1 дэх хэсэг, 103.1 дэх хэсэгт Улсын Их Хурал уг танилцуулгыг ажлын 5 хоногийн дотор сонсохоор тусгана.
- Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахад Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлэг, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор Байнгын хороон дээр дэмжигдээгүй саналыг тухайн санал гаргасан этгээд нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж, санал хураалгах хүсэлт гаргасан бол чуулганаар санал хураалгахаар өөрчлөн тусгана.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд санал хураалт явуулах ерөнхий журамд өөрчлөлт оруулж чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төсөл, тодорхой асуудал хэлэлцэхдээ Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонх дэмжсэн, дэмжээгүйгээс үл хамаарч эрх бүхий этгээдийн анх гаргасан саналыг нь дэмжих эсэхээр санал хураах агуулгатай зохицуулалт нэмэхээр тусгана.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26.1 дэх хэсэг, 103.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, Улсын Их Хурал Засгийн газрын гишүүнээр томилох тухай асуудал болон Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, огцруулах, түүнтэй холбогдуулан шинээр томилох асуудлын талаарх Ерөнхий сайдын танилцуулгыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор сонсохоор тусгана.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим хэсэгт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хугацаанаас өөрөөр тусгасныг Үндсэн хуульд нийцүүлж өөрчилнө.

Түүнчлэн хуулийн төслийн 4 болон 5 дугаар зүйлд чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төсөл, тодорхой асуудал хэлэлцэхдээ Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүд дэмжсэн, дэмжээгүйгээс үл хамаарч эрх бүхий этгээдийн анх гаргасан саналыг нь дэмжих эсэхээр санал хураахаар тусгахтай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Байнгын хорооны саналаар санал хураахаар заасан зохицуулалтуудад өөрчлөлт оруулахаар бэлтгэнэ.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхэд холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтээр эхэлж санал хураах, Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэхэд холбогдох Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл холбогдох Байнгын хорооны саналаар эхэлж санал хураах зохицуулалтыг хүчингүй болгохоор бэлтгэнэ.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Ерөнхий сайдын Засгийн газрын гишүүнийг томилж, чөлөөлж, огцруулах асуудлыг Улсын Их Хуралд танилцуулахтай холбоотой товыг тогтоох, танилцах хугацаа тодорхой болно.

Гишүүдийн санал бодлыг хэлэлцэж буй асуудлын агуулга, зорилгод төвлөрүүлж, чуулганы нэгдсэн хуралдаанд оролцох бодит оролцоог баталгаажуулах нөхцөл бүрдэнэ.

Чуулганы шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал болон хариуцлагын байдал нэмэгдэх бөгөөд гишүүдийн оролцоо илүү тодорхой харагдаж, санал, байр суурь шийдвэрт шууд тусна.

Иргэд чуулганаар хэлэлцэж буй асуудлын утга, зорилгыг илүү сайн ойлгож, парламентыг төлөөллийн ардчиллын зарчмын дагуу ажиллаж байгаа ард түмний итгэх итгэл нэмэгдэнэ.

Шийдвэр гаргах үйл явцад оролцоогүй гишүүдийн ирцээс шалтгаалсан үр дүнгийн гажуудлыг багасгана.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл, хэсэгт заасан хугацааг Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар:

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Үндсэн хуулиар Улсын Их Хуралд олгосон эрхийн хүрээнд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг илүү ойлгомжтой, ил тод, нэгдмэл байлгах зорилготой болно.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах бөгөөд энэ өөрчлөлт нь зөвхөн санал хураалттай холбогдох заалтад хамаарна.

--oOo--